

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт
Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар
2024 оны жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх								
1		1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж,		- Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; - Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх; - Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших; - Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж		1,000,000 төгрөг	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 17 (давхардсан тоогоор) контентыг орон нутгийн BBS телевиз, Сүхбаатарын өнгө сонин, SB инфо сайт болон аймаг, сум, агентлаг, байгууллагуудын албан ёсны цахим хуудас, сошиал хуудас, мэдээллийн самбар нийт 295 сувагт байршуулан аймгийн 60 гаруй мянган иргэдэд хүргэж ажилласан. Ингэхдээ сум, агентлаг, байгууллага бүр албан ёсны цахим хуудас, фэйсбүүк хуудас, мэдээллийн самбар ажиллуулж тэдгээрт авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх мэдээлэл, Авлигатай тэмцэх газарт мэдээлэл өгөх сувгуудын талаар цэс, булантайн зэрэгцээ орон нутгийн хандалт өндөртэй сошиал группуудад дээрх контентуудыг хуваалцаж, мэдээллийг түгээж ажилладаг. Хавсралт : 9 зураг	100%

		олон нийтэд хүргэх		хэвших.				
2		1.2. Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах		- Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; - Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; - Үр дүнг тооцсон байх.		5,000,000 төгрөг	Аймгийн хэмжээнд 5 сум, 6 агентлаг нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, нийт 3000 гаруй иргэд оролцсон байна. Өдөрлөгүүдийн үеэр байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүртээмж, ажилтнуудын харилцаа хандлага, ёс зүйн талаар судалгаа, санал хүсэлтийг санал хүсэлтийн хайрцгаар, амаар, цаасаар, цахимаар зэрэг олон төрлийн арга хэрэгслээр хүлээн авч, зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлэж хариуг өгч ажилласан бөгөөд зарим байгууллага иргэдээс авсан санал асуулгад дүн шинжилгээ хийж, албан хаагчдад танилцуулах, үйл ажиллагаагаа сайжруулахаар бодлого шийдвэртээ тусгах зэргээр ажиллажээ. Мөн зарим өдөрлөгийн үеэр АТГ-ын болон өөрсдийн бэлтгэсэн гарын авлага, материалыг иргэдэд тарааж ажилласан байна. Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газраас 16 сургууль, 24 цэцэрлэгийн бүх албан хаагчдад Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай танилцах чиглэлийг хүргүүлж, биелэлтийг хангуулж ажилласан. Хавсралт : 5 зураг	100%
3		1.3. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт		- Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх; - Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл	-		Нийтийн албан тушаалтнуудад Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигыг мэдээллэхэд чиглэсэн сургалтын материал 3-ыг бэлтгэн сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтын үеэр АТГ-аас бэлтгэсэн 12 төрлийн 120 зурагт хуудас, ном, гарын авлагыг тарааж ажилласан. Мөн Орон нутгийн өмчийн газраас бэлтгэсэн гарын авлага, броюшурт авлигын талаар мэдээллэх утсыг байршуулж, иргэдэд хүргэсэн. Асгат сумын ЗДТГ-аас санаачилан "Бид авлига авахгүй, өгөхгүй" стикер наалт хийж, иргэд, үйлчлүүлэгчидэд тарааж ажилласан. Хавсралт нийт : 5 Файл : 3 Зураг : 2	100%

		авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах		материалд оруулсан байх; - Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх; - Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.				
4		1.4. Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх		- Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; - Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх; - Олон нийтэд түгээсэн байх.		0	Өөрсдийн хийсэн видео контент байхгүй.	0%

2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх

5	2.1. “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх;	- Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх; - Сонгосон чиглэлд олон нийтийг хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх; - Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах; - Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх.	Томилолтын зардал	"Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын хэрэгжилтийг тайлангах албан хаагчдыг томилж, холбогдох мэдээллийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, уг албан хаагчийг чадавхжуулах сургалтад хамруулсан.	30%
6	2.2. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл	- Салбарт бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус	0	Тус аймагт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын судалгааг салбар бүрээр нэгтгэн гаргахад бүртгэлтэй 141 ТББ байгаагаас авлигатай тэмцэх зорилго, чиглэл бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын	70%

	ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх		байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх; - Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх; - Үр дүнг тооцож, тайлагнасан байх			хөдөлгөөнийг хараахан байгуулагдаагүй байна. Авлигатай тэмцэх газраас жил бүр иргэний нийгмийн байгууллагатай хамтран зохион байгуулдаг "Шударга байдлын үнэлгээ"-2024 судалгааг зохион байгуулахад Бодлогын шийдэл ТББ-ын судалгааны ажилтантай хамтран ажиллаж, байгууллагын 30 албан хаагч, эрдэмтэн, судлаачдын төлөөлөл 30 хүн, үйлчлүүлэгч 200 хүнийг хамруулахад дэмжлэг үзүүлж ажилласан.	
7	2.3. Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж,		- 2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх; - Төсвийн хөрөнгө	0		"Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем" аппликейшнаар дамжуулан 2024.03.01-2024.04.01-ний хооронд төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн саналыг иргэд олон нийтээс авах ажлыг зохион байгуулж, 5 санал ирсэн бөгөөд уг саналуудыг төлөвлөлтөд тусгаж ажилласан. Мөн www.publicinvestment.gov.mn цахим хуудсаар хөрөнгө оруулалтын хэрэгжилт, явц, гүйцэтгэлийн талаар мэдээллийг нээлттэй мэдээлж хэвшсэн. Мөн Төвсийн тухай хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу "Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах" арга хэмжээг зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан.	100%

		иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах		оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээг авах; - Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх.				
8	2.4. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж		- Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах; - Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших; - Иргэд,	0	Иргэдийн санал, хүсэлт, гомдлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны А/35 дугаар тушаалаар баталсан “Нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтнуудын иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь”-ийн дагуу биечлэн, санал хүсэлтийн хайрцагаар, нээлттэй утас 70510111 дугаарын утсаар, цаасаар, цахимаар хүлээн авч ажилладаг бөгөөд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын хэмжээнд улирал бүр өргөдөл гомдлын мэдээг нэгтгэн авч, дүгнэж хэвшсэн. 2024 оны өргөдөл гомдлын мэдээг авч нэгтгэвэл аймгийн нийт төрийн захиргааны байгууллагад 7878 өргөдөл гомдол, санал хүсэлт, талархал ирсний 7649 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлт 97.09%-ийн үзүүлэлттэй, хугацаа болоогүй 209 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд судлагдаж байна. Төрийн байгууллагад ирсэн нийт өргөдлийн тоо өмнөх оноос 3,045-аар буюу 28.5%-аар буурч, өргөдөл гомдлын	100%		

		хэвших		олон нийтээс Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх.		шийдвэрлэлтийн хувь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна. Аймгийн хэмжээнд төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг төрлөөр нь авч үзвэл: мэдэгдэл буюу Үндсэн Хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан 10, гомдол буюу төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан 21, санал буюу төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан 4, хүсэлт буюу байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад асуудлаар 7843 өргөдөл ирсэн байна. Өргөдөл гомдлын мэдээнд дүн шинжилгээ хийж, боловсрол, эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдад сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн. Хавсралт : 1 зураг	
3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах							
9		3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг		- Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах; - Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх; -	-	2021-2023 оны хооронд Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийг 13 сумын ИТХурал, ЗДТГазар, ЕБС, СӨБ, Соёлын төвүүд, 26 агентлаг, Эрүүл мэндийн төв зэрэг нийт 135 байгууллагад нэвтрүүлээд байна. Төрийн захиргааны байгууллагад нэвтрүүлсэн хувь 100% Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолын дагуу төрийн үйлчилгээний нэгдсэн систем "e-mongolia.mn"-ийг 2021 онд нэвтрүүлж улсын хэмжээнд үзүүлж байгаа үйлчилгээнээс гадна аймгийн хэмжээнд 13 байгууллагын 67 үйлчилгээ (e-business 58, иргэнд зориулсан 9) цахим хэлбэрт шилжүүлсэн. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн захиргааны байгууллагын хувь 70% 2024 онд төрийн цахим үйлчилгээний системээр дамжуулан нийт 10679 үйлчилгээг үзүүлээд байна.	100%

		дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах		Хэрэгжилтийг тайлагнах.				
10		3.2. Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;		- Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших; - Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх; - Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод	0	Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага сэдэвт сургалтыг Нээлттэй засаглалын түншлэл өдөрлөгийн үеэр төрийн байгууллагын удирдах албан тушаалтнууд, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Татварын хэлтэс, Цаг уур орчны шинжилгээний газар, Санхүүгийн хяналт аудитын алба, Худалдан авах ажиллагааны газар, Авто тээврийн төв зэрэг байгууллагуудад явуулж, 9 удаагийн сургалтад 178 төрийн албан хаагчид хамрагдсан. Авлигатай тэмцэх газартай хамтран 09 дүгээр сард Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг танилцуулах сургалт, 12 дугаар сард Авлигын эсрэг соён гэгээрүүлэх сургалтыг тус тус зохион байгуулж, аймгийн ЗДТГ, ИТХ-ын ажлын алба, агентлаг байгууллагын удирдах ажилтнууд, ахлах мэргэжилтнүүдэд зохион байгуулж, давхардсан тоогоор 206 албан хаагч хамрагдсан. Мөн байгууллагууд даргын тушаалаар дотоод хяналтын нэгж байгуулан, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Хавсралт : 10 зураг	100%	

				хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх;				
11	3.3. Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх		- Төлөвлөгөөний 1.1-3.2 дахь хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давхцахгүй байх; - Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээний онцлогт тохируулан зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх; - Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх; - Үйлчилгээ авдаг, хамтарч ажилладаг, зорилтот бүлэгт	0	Аймгийн ЗДТГ, Баруун-Урт, Мөнххаан сумдын ЗДТГ, Онцгой байдлын газар, Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 стандартыг нэвтрүүлэн хэрэгжүүлж байна. Ингэснээр үйлчилгээ, үйл ажиллагаа зураглалын дагуу хийгдэж, хүнд суртал, чигрэгдэл үүсэх нөхцөл багассан. Санхүүгийн хяналт аудитын албанаас Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжийн дагуу 2 байгуулга, аймгийн Засаг даргын баталсан нэгдсэн төлөвлөгөөний дагуу 45 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийв. Шалгалтаар илэрсэн зөрчилд 17 салбар акт, албан шаардлага тогтоосон, зөвлөмж өгч ажилласан. Худалдан авах ажиллагааны газраас “Тендерт оролцож буй компаниудад заавар зөвлөгөө өгөх групп” нэртэй фэйсбүүк группыг хөтөлж, түүгээр дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээллийг түгээдэг. Энэ онд дээрх хуудсуудаар 129 тендерийн зарыг ил тод нээлттэй нийтэлж оролцогч орох тэгш боломжийг хангаж ажилласан. Тус аймгийн нийтийн албан тушаалтнуудаас авлига, албан тушаалын гэмт хэрэгт шүүхээр ял шийтгүүлсэн хүн байхгүй бөгөөд АТГ-аас ирүүлсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай мөрдөгчийн мэдэгдлийг хүлээн авч, мэдэгдэлд дурдсан арга хэмжээг хэрэгжүүлж, хариу албан бичгээр хүргүүлж ажилласан. Дээрх мэдэгдлүүдийн мөрөөр Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлийн 3 удаагийн сургалт, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдах авах тухай хуулиар 1 удаагийн сургалт зохион байгуулж, холбогдох албан хаагчдыг хамруулсан бөгөөд 1 албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулсан байна.	100%		

				урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийсэн өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл хүргэсэн байх.				
--	--	--	--	---	--	--	--	--